



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/275

Улаанбаатар хот

Цагийн ажлын төрөл, жишиг хөлсний хэмжээ батлах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 66, 103 дугаар зүйлийн 103.3, ШУТИС-ийн дүрмийн 4.9.2, 4.14.2, 10.2, ШУТИС-ийн захирлын зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагийн ажлын төрөл, жишиг хөлсний хэмжээг нэгдүгээр хавсралтаар, ажлын гүйцэтгэлийг тооцох хуудсыг хоёрдугаар хавсралтаар, цагийн ажлын зарын загвар хуудсыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Цагийн ажлын зар мэдээлэл хүргэх, холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд ажилд зуучлахтай холбоотой үйл ажиллагааг хариуцан ажиллахыг Оюутны хөгжил, соёл, үйлчилгээний алба (Н.Санчирбаатар)-д үүрэг болгосугай.
3. Ажлын гүйцэтгэл тооцох хуудсыг үндэслэн ажлын хөлсийг батлагдсан жишгээр олгох, холбогдох тооцоог зохих журмын дагуу хийхийг бүрэлдэхүүн сургуулийн захирал, ахлах нягтлан бодогч нарт үүрэг болгосугай.
4. Энхүү тушаалыг 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс мөрдсүгэй.

ЗАХИРАЛ



Т.НАМНАН



ШУТИС-ийн захирлын 2023 оны 09 дүгээр сарын өдрийн 125 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Цагийн ажлын төрөл, жишиг хөлсний хэмжээ

| № | Гүйцэтгэх ажлын төрөл, нэр | Хэмжих нэгж | Нэгжийн үнэлгээ (₮) | Тайлбар |
|--|--|------------------|---------------------|---|
| Үйлчилгээ, зохицуулагчийн ажил | | | | |
| 1 | Цэвэрлэгээ, үйлчилгээ | Хичээлийн танхим | 5000 | Хичээлийн байр, номын сан |
| 2 | Цэвэрлэгээ (оюутны байр) | 100M2 | 5000 | Нийтийн эзэмшлийн талбай |
| 3 | Цэвэрлэгээ (гадна талбай) | 1 цаг | 5000 | Захиалагчийн хяналтан дор хөнгөн цэвэрлэгээ хийх |
| 4 | Авто зогсоолын зохицуулагч | 1 цаг | 5000 | Автомашиныг эмх цэгцтэй байрлуулах |
| Чиглүүлэгч, туслахын ажил | | | | |
| 5 | Чиглүүлэгч оюутан | 1 цаг | 5000 | |
| 6 | Туслах ажилтан, бэлтгэл тогооч, зөөгч хийх | 1 цаг | 5000 | Оюутны зоогийн газар |
| Мэдээлэл сурталчилгаа, хэвлэл, эх бэлтгэлийн ажил | | | | |
| 7 | Сонин, сэтгүүлийн хэвлэлийн дизайн, эх бэлтгэх | 1 цаг | 5000 | |
| 8 | Видео эвлүүлэг, зураглаач хийх | 1 цаг | 5000 | Маркетингийн контент хийх |
| 9 | График дизайн хийх | 1 цаг | 10000 | Видео контентийн хөдөлгөөнт дүрс, сурталчилгааны шторк бэлтгэх |
| 10 | Маркетинг, PR-ийн туслах ажилтан | 1 цаг | 5000 | |
| 11 | Нэвтрүүлэгч, хөтлөгч | 1 цаг | 5000 | Видео болон аудио контент |
| 12 | Хэвлэлийн эх бэлтгэгч | Хэвлэлийн хуудас | 5000- 20000 | Хийж гүйцэтгэх ажлын даалгавраас хамааран 4 зэрэглэлээр хөлсийг тооцно. |
| 13 | Дэвтэрлэгч | 1 цаг | 5000 | |
| 14 | Хөтлөгч | 1 цаг | 30000-50000 | Арга хэмжээний далайц хэмжээнээс хамаарна. |
| 15 | Заалны техникч | 1 цаг | 10000 | Хөгжим, техникийн авьяастай оюутнаар заалны техник хариуцуулан ажлуулах |
| Номын сан, мэдээлэл технологийн ажил | | | | |
| 16 | Номын санч | 1 цаг | 5000 | |
| 17 | Сүлжээний кабель сувагчлах, компьютер засах | 1 цаг | 8000 | Мэдээлэл, технологийн төвийн захиалгаар |
| 18 | Программ тестлэх, нэмэлт модуль хөгжүүлэх, засах | 1 цаг | 12000 | Мэдээлэл, технологийн төвийн захиалгаар |

Жич: Бүрэлдэхүүн, нэгжүүд бусад чиглэлээр оюутан, суралцагсдыг цагийн хөлсөөр ажиллуулж болно.



Ажлын гүйцэтгэлийг гооцох хуудас

| № | Үндсэн нөхцөл | Бөглөх хэсэг |
|---|-------------------------|--------------|
| 1 | Гүйцэтгэгчийн нэр | |
| 2 | Захиалагч | |
| 3 | Үндсэн даалгавар | |
| 4 | Ажилласан хугацаа | |
| 5 | Хөлсний нийт дүн (₮) | |

Гүйцэтгэлийн үнэлгээ

| Үнэлгээ | Муу | Дунд | Сайн |
|---------|-----|------|------|
| | | | |

Шалгасан:

Хөлсийг олгосон:



ШУТИС-ийн захирлын 2023 оны 09 дүгээр сарын
06 өдрийн 4/27 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

Цагийн ажлын зарын загвар хуудас

| № | Үндсэн чиглэл | Бөглөх талбар |
|----|--|---------------|
| 1 | Гүйцэтгэх ажил | |
| 2 | Захиалагч алба нэгж, сургууль | |
| 3 | Олгох хөлс (₮) | |
| 4 | Ажил гүйцэтгэх байршил, газар | |
| 5 | Хүний тоо | |
| 6 | Ажиллах хугацаа | |
| 7 | Тавигдах шаардлага | |
| 8 | Тайлбар | |
| 9 | Захиалагч нэгжийн холбоо барих албан тушаалтан, утасны дугаар, байршил | |
| 10 | Бусад нөхцөл | |